



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

Зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс түр чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдах намрын ургац хураалтын хүнсний улаан буудайд тооцогдох Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын дагуу Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчид /брокер/-аас төвлөрүүлдэг арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0.04 хувьтай тэнцэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд чөлөөлсүгэй.

2. Энэхүү тогтоолтой нийцүүлэн биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, энэ тогтоолын 1-д зааснаас бусад хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжаалсан зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хорооны дансанд сар бүрийн эцэст төвлөрүүлж ажиллахыг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /Ж.Осоржамаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН